



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/36/СТА-ТӨҮГ

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Цахим хуудас: www.audit.mn

САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор: Р.Цолмон
Утас: 261885
Цахим хаяг: Rtslmn2003@yahoo.com

“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн

Аудитор: С.Уянга
Утас: 70110799, 99098007
Цахим хаяг: uyanga.s@mn.gt.com

Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн:
Б.Эрдэнэбат
Утас: 70110799, 99124000
Цахим хаяг: erdenebat.b@mn.gt.com

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо
Юнескогийн гудамж-31,
Далай тауэр, 9 дүгээр давхар

АУДИТЫН ТАЙЛАН

- 1: Аудитын гэрчилгээ
- 2: Менежментийн захидал
- 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2018 оны 3 дугаар сар



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	1
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
2.5	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.6	Дотоод хяналт.....	5
2.7	Зорилтот түвшингийн талаарх тайлбар, тодруулга.....	5
2.8	Шилэн дансны мэдээлэл	5
2.9	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.10	Аудитын явцад илрүүлсэн гол алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.10.1	Авлагын талаар	5
2.10.2	Зардлын талаар.....	6
2.10.3	Томилолтын зардлын талаар	6
2.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.12	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.14	Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал	8
3.1	Зардлын талаар.....	9
3.2	Томилолтын зардлын талаар	9
3.3	Авлагын талаар	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5	Аудит хийгдсэн зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.БААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, санхүү байдлын нэмэлт тодруулга, материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн ерөнхий захирал Х.Баатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан сангийн сайдын баталсан заавар, журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 27-ноос 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 13-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн аудитор С.Уянга, Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн Б.Эрдэнэбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 59 дүгээр албан бичгээр “Улаанбаатар аудит корпораци” ХХК-д ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК санхүүгийн үйл ажиллагаандаа Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, бусад холбогдох хуулиудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 102,170 мянган ширхэг энгийн, 500,000 ширхэг зарласан хувьцаатай бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,021.7 сая төгрөг 100 хувь төрийн эзэмшилд байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар ба эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн эрхэм зорилго нь Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, таваарын оновчтой тогтолцоо бүхий зах зээлийг үүсгэн зохион байгуулах, төлөвшүүлэх, оролцогчдод зах зээлийн бодит үнэ хүргэхэд оршино.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасны дагуу арилжаанд оролцох үндсэн шалгуур нь зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан хуулийн этгээд байхаар заасан байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төлөвлөгөөний гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төлөвлөгөөний гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 14 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь санхүүгийн тайлангаа “Impact” санхүүгийн програм хангамжаар бэлтгэсэн байна.



2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.6 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дотоод хяналтыг гүйцэтгэлийн шатанд хянахад, тайлант онд Захиргаа дотоод аудитын хэлтэс нь санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй учир компанийн дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

2.7 Зорилтот түвшингийн талаарх тайлбар, тодруулга

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулсан ба уг зорилтот түвшинг 2017 оны 12 дугаар сарын 12-ны Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 649 дүгээр тогтоолоор орлогыг 100.0 сая төгрөгөөр, зардлыг 210.2 сая төгрөгөөр нэмж, нэмэлт тодотгол оруулсан байна.

Нийт 1,550.4 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөн гүйцэтгэлээр 1,922.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн ба 1,594.6 сая төгрөгийн зардлыг төлөвлөн, гүйцэтгэлээр 1,435.5 сая төгрөгийг зарцуулан, зардлыг хэмнэж ажилласан байна.

2.8 Шилэн дансны мэдээлэл

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу www.shilendans.gov.mn хуудсанд шаардлагатай мэдээллийг тавьж ажилласан байна.

2.9 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэв.


Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.10 Аудитын явцад илрүүлсэн гол алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.10.1 Авлагын талаар

Ажиллагсадтай холбоотой 2015 онд үүссэн 1.2 сая төгрөгийн авлагын барагдуулах арга хэмжээ аваагүй, насжилт хэтэрсэн эдгээр авлагад найдваргүй авлагын зөрчил байгаагүй, өнөөг хүртэл санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр илэрхийлсээр байна.



Шийдвэрлэсэн нь:

Авлагыг барагдуулах арга хэмжээ авах, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

2.10.2 Зардлын талаар

Тайлант онд хийгдсэн НББ-ийн дансны бичилтүүдийг хянаж үзэхэд 334.1 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.10.3 Томилолтын зардлын талаар

2017 оны 9 дүгээр сард БНХАУ-ын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор явсан 3 хүний томилолтын зардал 11.4 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүй, томилолтын тооцоо бодоогүй, үүнээс 9.4 сая төгрөгийг үндэслэх анхан шатны баримтгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

2.11 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай холбоотой анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай холбоотой дараагийн аудитаар зайлшгүй авч үзэх шаардлагатай асуудлууд гараагүй болно.


2.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **516.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба **89.4** сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, **78.0** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **349.2** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

2.14 ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК аудит хийсэн ба нийт 664.7 сая төгрөгийн 9 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, доорх 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Доор дурьдсан 3 зөвлөмж нь хуулийн байгууллагад шалгагдаж байгаа учир хэрэгжих боломжгүй байна.

1. “NASDAQ” группийн Арилжаа клирингийн цогц системийн програм хангамж суулгахтай холбоотой Монгол улсын эх үүсвэрээс олсон зөвлөмж үйлчилгээний 193.1 сая төгрөгийн



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгдсэн Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 ЗАРДЛЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд хийгдсэн НББ-ийн дансны бичилтүүдийг хянаж үзэхэд 334.1 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцоо үүсгэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Байгууллагын мөнгө шамшигдах эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалын дагуу зардлын данснаас холбогдох дансаар дамжуулан гүйлгээг хийж байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.2 ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2017 оны 9 сард БНХАУ-ын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор явсан 3 хүний томилолтын 11.4 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүйгээр, 9.4 сая төгрөгийг дэмжих баримтгүйгээр зардалд бүртгэсэн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалыг мөрдөж ажиллаагүй.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийг 2018 ны 6 дугаар сарын 20-ны дотор багтаан хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Үндэсний аудитын газарт тайлагнах.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.



3.3 АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Ажиллагсадтай холбоотой 2015 онд үүссэн 1.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, насжилт хэтэрсэн эдгээр авлагад найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, өнөөг хүртэл санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр илэрхийлсээр байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу идэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

1. Авлагыг барагдуулах арга хэмжээ авах, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.
2. Зөвлөмжийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор багтаан хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Үндэсний аудитын газарт тайлагнах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	758,398,246.66	1,006,323,183.53
1.1.2	Дасны авлага	8,936,338.89	291,250,192.74
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	52,442,974.42	52,442,974.42
1.1.4	Бусад авлага	8,551,920.73	8,551,920.73
1.1.5	Бараа материал	20,924,457.75	20,924,457.75
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	377,416,085.27	377,416,085.27
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,756,913,114.57	1,756,908,814.44
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	206,453,417.94	206,453,417.94
1.2.2	Биет бус хөрөнгө	136,588,761.53	136,588,761.53
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	343,042,179.47	343,042,179.47
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,795,861,015.83	2,099,950,993.91
2.1	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1	Дансны өглөг	20,000,000.00	17,783,762.80
2.1.2	Цалингийн өглөг	-	22,954.63
2.1.3	Татварын өр	6,240,293.35	185,756.04
2.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	0.10	22,543.33
2.1.7	Ногдол ашгийн өглөг	77,980,000.00	77,980,000.00
2.1.8	Урьдчилж орсон орлого	2,809,472.91	1,265,753.42
2.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,002,700.45	1,002,700.45
2.1.12	Хувьцааны өр төлбөр	1,272,000,000.00	1,129,650,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,380,032,466.81	1,227,913,470.67
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2	Нөөц /өр төлбөр/	-	20,000,000.00
2.1.2	Хойшлогдсон татварын өр төлбөр	4,479,402.91	4,479,402.91
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,479,402.91	24,479,402.91
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,384,511,869.72	1,252,392,873.58
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч-Төрийн өмч	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(610,360,853.89)	(174,151,879.67)
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	411,349,146.11	847,558,120.33
	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,795,861,015.83	2,099,950,993.91



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,507,644,302.78	1,867,167,114.06
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	1,507,644,302.78	1,867,167,114.06
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	61,802,430.24	55,080,328.72
Бусад орлого	23,461,111.00	-
Борлуулалт, маркетингийн зардал	6,663,150.00	5,305,071.46
Ерөнхий ба удирдлагын зардал	1,611,386,997.02	1,428,248,662.33
Бусад зардал	10,344,011.21	1,973,192.49
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	428,905.64	(111,662.47)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(149,795,833.00)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(184,853,241.57)	486,608,854.03
Орлогын татварын зардал	6,180,243.02	50,399,879.81
Татварын дараах ашиг (алдагдал)	(191,033,484.59)	436,208,974.22
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-
Орлогын нийт дүн	(191,033,484.59)	436,208,974.22
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	(419,327,369.30)	602,382,630.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн			(191,033,484.59)	(191,033,484.59)
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	(610,360,853.89)	411,349,146.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн			436,208,974.22	436,208,974.22
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	(174,151,879.67)	847,558,120.33



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	111,068,402,199.83	218,800,051,967.94
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,511,326,884.40	1,644,522,575.14
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	109,358,315,700.00	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,234,568.00	-
	Бусад орлого	195,525,047.43	217,155,529,392.80
1.2	Мөнгөн зарлагын дүн	111,216,214,116.32	218,459,822,717.46
	Ажиллагчдад төлсөн	705,531,735.36	844,661,288.37
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	183,646,356.49	269,612,313.06
	Бараа материал худалдан авахад төлсөн	14,537,219.98	62,150,144.11
	Ашиглалтын зардалд төлсөн	353,373,182.52	-
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,997,533.63	19,619,949.98
	Хүүний төлбөрт төлсөн	25,933,362.09	-
	Татварын байгууллагад төлсөн	119,875,853.50	-
	Бусад мөнгөн зарлага	109,800,318,872.75	217,263,779,021.94
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(147,811,916.49)	340,229,250.48
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	61,802,430.24	54,977,705.23
	Хүлээн авсан хүүний орлого	61,802,430.24	54,977,705.23
2.2	Мөнгөн зарлагын дүн	276,033,666.42	4,820,356.37
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,146,000.00	4,820,356.37
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	646,365.50	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	222,241,300.92	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(214,231,236.18)	50,157,348.86
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	1,272,429,864.27	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,272,000,000.00	-
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	429,864.27	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	250,000,000.00	142,461,662.47
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	250,000,000.00	-
	Төлсөн ногдол ашиг	-	142,350,000.00
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	111,662.47
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,022,429,864.27	(142,461,662.47)
	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	660,386,711.60	247,924,936.87
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,011,535.06	758,398,246.66
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	758,398,246.66	1,006,323,183.53



4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,594,555,290.00	1,435,526,926.28	159,028,363.72	90%
Үндсэн цалин	820,080,000.00	775,805,422.00	44,274,578.00	95%
ЭМНДШ-ийн зардал	88,954,800.00	80,645,997.00	8,308,803.00	91%
Гадаад томилолтын зардал	31,500,000.00	13,909,243.36	17,590,756.64	44%
Дотоод томилолтын зардал	13,995,000.00	10,655,801.68	3,339,198.32	76%
Гадаад, дотоод сургалт	9,000,000.00	7,005,000.00	1,995,000.00	78%
Маркетинг сурталчилгааны зардал	29,740,000.00	5,305,071.46	24,434,928.54	18%
Түрээсийн зардал	173,209,090.00	159,342,302.99	13,866,787.01	92%
Нийгмийн хамгаалал, хүний нөөцийн үйл ажиллагааны зардал	33,800,000.00	16,250,000.00	17,550,000.00	48%
Элэгдлийн зардал	268,855,000.00	263,378,755.19	5,476,244.81	98%
Харилцаа холбооны зардал	15,531,400.00	11,869,274.26	3,662,125.74	76%
Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал	3,300,000.00	3,600,000.00	(300,000.00)	109%
Даатгалын зардал	500,000.00	896,620.00	(396,620.00)	179%
Түлш, шатахууны зардал	16,590,000.00	6,738,942.38	9,851,057.62	41%
Засвар үйлчилгээ	4,000,000.00	1,301,272.73	2,698,727.27	33%
Материал, сэлбэг хэрэгсэл, хангамжийн зардал	35,500,000.00	28,823,223.23	6,676,776.77	81%
Хуулийн зардал	50,000,000.00	50,000,000.00	-	100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,550,425,800.00	1,922,247,442.78	(371,821,642.78)	124%
Арилжааны шимтгэлийн орлого	1,535,425,800.00	1,828,158,022.76	(292,732,222.76)	119%
Бусад орлого	15,000,000.00	94,089,420.02	(79,089,420.02)	627%
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСАД БҮГД	40	40	-	
Удирдах ажилтан	7	7	-	
Гүйцэтгэх ажилтан	31	31	-	
Үйлчлэх ажилтан	2	2	-	

